

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 389 дугаартай албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Налайх дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг хавсралтаар баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Налайхын дулааны станц” ТӨХК /Ц.Энхтүвшин/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тарифын газар /Б.Эрдэнэбулган/-т даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 668 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	1,870.0
		Төг/Гж	56,170.0
2	Төсвийн байгууллагын халаалт	Төг/м ³	3,775.0
		Төг/Гж	66,082.0
3	Төсөвт болон үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	11,781.0
		Төг/м ³	11,750.0

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф		
1	Орон сууцны халаалт (орц, хонгилын хэсэг, "00"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1,400.0		
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	4,887.5
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	6,842.5
		Усны зарцуулалтаар	Төг/м ³	11,650.0	
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф				
3.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	6,000.0		
3.2	40 м ² -аас 80 м ² талбайтай айл өрх	Төг/сар	10,000.0		
3.3	80 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	20,000.0		